

**МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2026 оны 04 сарын 20

№ 26/ТУЗ/22

Улаанбаатар хот

Компанийг нэгтгэх тухай шийдвэрийн төсөл болон компанийг нэгтгэх гэрээний төслийг
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулах тухай

Компанийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.2 дахь заалт, 20.4, 62 дугаар зүйлийн 62.1.2 дахь заалт, Монложистикс Холдинг ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.14.22 дахь заалт, 2026 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ээлжит бус хурлын санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ**:

1. Энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтад заасан Компани нэгтгэх шийдвэрийн төсөл болон хоёрдугаар хавсралтад заасан Компани нэгтгэх гэрээний төслийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж, хэлэлцүүлэхийг зөвшөөрсүгэй.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Г. Хишигбат/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д. ГАНЗОРИГТ

“Монложистикс Тракинг ХХК-ийг Монложистикс Холдинг ХК-д нэгтгэхийг зөвшөөрөх тухай Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төсөл”


Компанийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.2, 20.4 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.2 дахь заалт, “Монложистикс Холдинг” ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.9.2 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн ээлжит хурлын Тооллогын комиссын шийдвэрийг тус тус үндэслэн Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. “Монложистикс Тракинг” ХХК-ийн үйл ажиллагааг зогсоож, түүний эрх, үүрэг, хариуцлага, хөрөнгө, өр төлбөрийг бүхэлд нь “Монложистикс Холдинг” ХК-д нэгтгэсүгэй.
2. Монложистикс Тракинг ХХК нь Монложистикс Холдинг ХК-ийн 100 хувийн охин компани байсан болохыг дурдсугай.
3. “Монложистикс Тракинг ХХК”-ийг “Монложистикс Холдинг” ХК-д нэгтгэх тухай Төлөөлөн удирдах зөвлөлөөс танилцуулсан компани нэгтгэх гэрээг байгуулахыг зөвшөөрсүгэй.
4. “Монложистикс Холдинг” ХК-ийг төлөөлж Компани нэгтгэх гэрээнд гарын үсэг зурах, нэгтгэх үйл ажиллагаанд Компанийг төлөөлөх эрхийг Гүйцэтгэх захирал /Г.Хишигбат/-д олгосугай.
5. Нэгтгэх үйл ажиллагааг хуульд заасан журмын дагуу хийж гүйцэтгэж, тайлагнаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Г.Хишигбат/-д үүрэг болгосугай.
6. Энэхүү шийдвэрийг болон шаардлагатай баримт бичиг, мэдээллийг холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу олон нийтэд мэдээлэх, Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэхийг ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга /Ц. Дуламсүрэн/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Г. ХИШИГБАТ

“Монложистикс Холдинг” ХК-ийн Төлөөлөн
Удирдах Зөвлөлийн 2026 оны 4 сарын 20-ны өдрийн
№ 26/ТУЗ/22 тогтоолын Хавсралт №2



**“Монложистикс Тракинг ХХК-ийг Монложистикс Холдинг ХК-д
нэгтгэх гэрээний төсөл”**

Энэхүү “Нэгтгэх гэрээ” /цаашид “Гэрээ” гэх/-г

Нэг талаас: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Олимпын гудамж, Нью Хоризонс оффис, 1101 тоот -бүртгэгдсэн хаягтай, Монгол Улсын хувьцаат компани болох “Монложистикс Холдинг” ХК (улсын бүртгэлийн дугаар 9007001019, регистрийн дугаар 6381251), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал албан тушаалтай Г.Хишигбат

Нөгөө талаас: Монгол Улс, Улаанбаатар хот, Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11 дүгээр хороо, Дүнжингарав, Зайсан Скүэр төв, 404 тоот - бүртгэгдсэн хаягтай, Монгол Улсын хязгаарлагдмал хариуцлагатай компани болох “Монложистикс Тракинг” ХХК (Улсын бүртгэлийн дугаар 9011824671, Регистрийн дугаар 6662951), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал албан тушаалтай А.Одгэрэл

нар /цаашид хамтад нь “Талууд” гэх/ Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг үндэслэн дараах нөхцөлийг харилцан тохиролцож энэхүү Гэрээг байгуулав.

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү гэрээний зорилго нь “Монложистикс Тракинг” ХХК-ийн бүх эрх, үүрэг, хөрөнгө, өр төлбөрийг “Монложистикс Холдинг” ХК-д шилжүүлэх замаар “Монложистикс Тракинг” ХХК-ийг “Монложистикс Холдинг” ХК-д нэгтгэхтэй холбоотой талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. ТАЛУУДЫН ЭРХ ҮҮРЭГ, ШИЛЖИЛТ

- 2.1. “Монложистикс Тракинг” ХХК-ийн нэгтгэл хийх үеийн бүх төрлийн хөрөнгө, эрх, үүрэг, гэрээ, өр төлбөр нь бүхэлдээ “Монложистикс Холдинг” ХК-д шилжинэ. Үүнд татварын өр төлбөр, гэрээний үүрэг, гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн хариуцлага багтана.
- 2.2. “Монложистикс Холдинг” ХК нь нэгтгэх шийдвэр гарснаас хойш хуульд заасан хугацаанд Санхүүгийн зохицуулах хороо болон холбогдох байгууллагад мэдэгдэнэ.

- 2.3. Нэгдэж байгаа компанийг улсын бүртгэлээс хассанаар, хэрэв нэгтгэсэн компанийн дүрэмд өөрчлөлт орсон бол түүнийг улсын бүртгэлд бүртгэснээр тэдгээрийг өөрчлөн байгуулагдсанд тооцно.
- 2.4. “Монложистикс Тракинг” ХК нь нэгтгэх шийдвэр гарснаас хойш ажлын 15 хоногийн дотор зээлдүүлэгч болон харилцагчдад бичгээр мэдэгдэнэ.

Гурав. ХӨРӨНГӨ, ӨР ТӨЛБӨРИЙН ТООЛЛОГО, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

- 3.1. “Монложистикс Тракинг” ХХК-ийг нэгтгэх тухай шийдвэр гарсны дараа Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасан хөрөнгө, өр төлбөр тооцооны тооллого хийх, санхүүгийн баталгаажсан тайлан гаргах зэрэг ажлыг 2 компанийн удирдлага, нягтлан бодох алба хамтран зохион байгуулна.
- 3.2. Талууд нэгдэж байгаа компанийн хөрөнгө, зөвшөөрөл, ажилтнуудыг шилжүүлэх, санхүүгийн баталгаажсан тайлан гаргах, харилцагч, зээлдүүлэгч нарт мэдэгдэх, өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэх зэрэг компани эцсийн байдлаар нэгтгэхтэй холбоотой үйл ажиллагааг хариуцах, зохион байгуулах багийг байгуулж болно.
- 3.3. Нэгтгэх үйл ажиллагааг Талуудын хувьцаа эзэмшигчийн шийдвэр гарч, гэрээ хүчин төгөлдөр болсон өдрийн дараагийн ажлын өдрөөр эхлүүлж, 2026 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн дотор бүрэн хийж дуусгах ба улсын бүртгэлд бүртгүүлэх ажлыг Монложистикс Холдинг хариуцна.
- 3.4. Нэгтгэх үйл ажиллагааг эхлүүлснээс хойш Монложистикс Тракинг ХХК-ийн үйл ажиллагааг зогсоох ба эрх, үүрэг хариуцлагаа шилжүүлэх, нэгтгэхтэй холбоотойгоос бусад асуудлаар шинээр гэрээ хэлцэл хийхгүй.
- 3.5. “Монложистикс Тракинг” ХХК-ийг “Монложистикс Холдинг” ХК-д нэгтгэж, бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдөж байгаатай холбогдуулан тус компанийн ажилтныг ижил төрлийн, ижил хугацаа, нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллуулна.
- 3.6. “Монложистикс Тракинг” ХХК-ийг Компанид нэгтгэсэн нь ажилтны Монгол Улсын хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийн дагуу эдлэх аливаа эрхийг хөндөхгүй байна.

Дөрөв. БУСАД

- 4.1. Энэхүү гэрээ нь талуудын эрх бүхий этгээдгарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.
- 4.2. Энэхүү Гэрээгээр зохицуулаагүй бусад харилцааг Гэрээ байгуулах үед Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж байсан хууль тогтоомжийн дагуу зохицуулна.
- 4.3. Талуудын хооронд Гэрээнээс үүдэн гарсан аливаа маргааныг эвийн журмаар, харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэх бөгөөд зөвшилцөлд эс хүрвэл маргааныг Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛСАН

“Монложистикс Холдинг” ХК-ийг төлөөлж:

Гүйцэтгэх захирал Г.Хишигбат

“Монложистикс Тракинг” ХХК-ийг төлөөлж:

Гүйцэтгэх захирал А.Одгэрэл

_____ /гарын үсэг/

_____ /гарын үсэг/